



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 54

Эрдэнэт


“Хүндэт иргэн” шагналаар
шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 120 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Эрдэнэт хотын өдрийг тохиолдуулан аймаг, орон нутгийн түүхэн хөгжил, бүтээн байгуулалтад оруулсан онцгой хувь нэмрийг нь үнэлж Ч.Доржпалам, Л.Бат-Очир, Р.Дашдондов нарыг Эрдэнэт хотын “Хүндэт иргэн” шагналаар шагнасугай.

2.Шагналд зарцуулагдах хөрөнгийг аймгийн төсвөөс гаргахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.МӨНХБАТ